



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/16

Пионер толгой

Тамхи худалдаалах үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тамхи худалдан борлуулах хүсэлт гаргасан Түүхт Ноён хайрхан ХХК-ий Ноён хайрхан хүнсний дэлгүүрт тамхи жижиглэнгээр худалдаалах тусгай зөвшөөрөл 5 жилийн хугацаатай олгосугай.

2.Тамхины хяналтын тухай хууль, холбогдох журмыг баримтлан ажиллахыг Түүхт Ноён хайрхан ХХК-ий захирал (Г.Ууганбаяр)-д, хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасгийн дарга (М.Ариунсан), хэсгийн төлөөлөгч (Дуламдорж) нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Гантулга)-д даалгасугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА



642201195